



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ТӨА-2025/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
	Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
	Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/170
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шалгагдагч байгууллагын үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 1,918.2 мянган төгрөгөөр илүү зарцуулсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардалд 14,484.7 мянган төгрөгийн албан томилолтын зардал, 29,405.0 мянган төгрөгийн интернэт сүлжээний зардал, 3,170.0 мянган төгрөгийн сургалтын зардал, 719.2 мянган төгрөгийн шагналын зардал, 1,152.0 мянган төгрөгийн аудитын үйлчилгээний төлбөр, 3,093.0 мянган төгрөгийн эмнэлгийн үзлэгийн төлбөр, 2,268.6 мянган төгрөгийн бусад жижиг зардлыг бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн дулааны талбайг тооцохдоо тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндрийн хэмжээгээр тодорхойлоогүй, барилгын эзлэхүүнийг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй байна.

410501201

Аудитын гол асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн хамт олны 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрээр тус журмын 12.1-д Тусламж, тэтгэмжийн хэсэгт өөрчлөлт оруулсныг үндэслэн сургуулийн захирлын 2024 оны А/23 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94,0%-ийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>306,534,187.78</u>	<u>433,127,448.22</u>
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	205,055,388.73	325,720,620.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	205,055,388.73	325,720,620.06
3121	Төгрөг	205,055,388.73	325,720,620.06
31211	Төрийн сангийн харилцах	205,055,388.73	325,720,620.06
33	АВЛАГА	11,137,460.89	22,168,200.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	10,846,160.89	110,900.00
335	Бусад авлага	291,300.00	22,057,300.00
3351	Байгууллагаас авах авлага	10,200.00	22,011,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	281,100.00	46,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,341,338.16	85,238,628.16
351	Түүхий эд материал	62,117,852.26	65,807,392.26
35110	Тусгай зориулалттай материал	61,476,252.26	65,165,792.26
35130	Эм боох материал	641,600.00	641,600.00
354	Хангамжийн материал	28,223,485.90	19,431,235.90
35450	Барилгын засварын материал	10,270,430.00	4,594,180.00
35460	Хүнсний материал	3,116,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	14,837,055.90	14,837,055.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,630,779,672.16</u>	<u>3,560,942,926.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,630,779,672.16	3,560,942,926.75
392	Биет хөрөнгө	3,549,879,672.16	3,476,253,297.20
39201	Барилга, байгууламж	3,468,412,857.82	3,454,906,846.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(322,322,630.24)	(361,235,377.32)
39203	Авто тээврийн хэрэгсэл	8,200,000.00	8,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,200,000.00)	(8,200,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	281,578,607.00	321,376,852.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,384,208.62)	(141,136,631.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	222,589,333.92	244,967,440.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(85,136,989.72)	(107,035,890.28)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	74,546,000.00	74,546,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(25,546,000.06)	(30,212,666.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,142,702.06	20,076,724.06
393	Биет бус хөрөнгө	80,900,000.00	84,689,629.55
39301	Програм хангамж	775,000.00	4,583,942.05
39302	Хасагдуулга	(775,000.00)	(794,312.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,900,000.00	80,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,937,313,859.94</u>	<u>3,994,070,374.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	<u>22,796,752.00</u>	<u>15,530,725.51</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,796,752.00	15,530,725.51
413	Өглөг	22,796,752.00	15,530,725.51
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	9,936,374.57
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,540,100.00	-
4136	Бусад өглөг	256,652.00	5,594,350.94
41361	Байгууллагад төлөх өглөг	246,652.00	657,452.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	10,000.00	4,936,898.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	<u>3,914,517,107.94</u>	<u>3,978,539,649.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,914,517,107.94	3,978,539,649.46

Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	383,740,312.86	383,740,312.86
51101	Өмч: -Төрийн өмч	383,740,312.86	383,740,312.86
512	Хуримтлагдсан үр дүн	1,890,489,671.49	1,973,075,024.01
51210	Өмнөх үеийн үр дүн	1,890,489,671.49	1,909,052,482.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	64,022,541.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,640,287,123.59	1,621,724,312.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,937,313,859.94	3,994,070,374.97

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,666,208,728.00	2,113,175,849.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,189,928.00	66,172,075.44
120	Нийтлэг татварын бус орлого	142,189,928.00	66,172,075.44
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	142,189,928.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,938,248.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,251,680.00	-
120009	Бусад орлого	-	31,311,682.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	34,122,173.44
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	738,220.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,524,018,800.00	2,047,003,774.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,261,871,600.00	1,734,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,261,871,600.00	1,734,977,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	262,147,200.00	312,026,374.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	262,147,200.00	312,026,374.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,446,354,481.41	2,046,153,307.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,446,354,481.41	2,046,153,307.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,401,794,366.87	2,021,047,627.92
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	803,626,924.20	1,256,109,184.80
210101	Цалин	665,014,463.65	1,029,455,095.50
210102	Нэмэгдэл цалин	138,612,460.55	186,607,628.30
210104	Урамшуулал	-	40,046,461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,933,067.79	151,617,404.92
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	73,020,384.64	99,120,069.08
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,761,326.20	13,998,120.69
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,582,661.18	6,196,211.78
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,659,480.36	6,114,017.76
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	28,909,215.41	26,188,985.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,768,382.46	289,284,473.91
210301	Гэрэл цахилгааны зардал	12,448,067.04	17,950,857.91
210302	Түлш, халаалтын зардал	251,320,315.42	269,803,616.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	1,530,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,615,040.00	16,835,346.00
210401	Бичиг хэргийн материал	4,517,540.00	9,218,260.00
210402	Тээвэр, шатахууны зардал	6,097,500.00	7,237,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	-	380,086.00
2105	Нормативт зардал	65,254,972.00	88,469,270.00
210501	Эм	-	925,000.00
210502	Хоол	62,104,172.00	81,952,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,150,800.00	5,591,300.00

**Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,145,640.00	19,263,610.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	962,000.00
210604	Урсгал засвар	3,145,640.00	18,301,610.00
2107	Томилолт, зочны зардал	-	9,299,000.00
210702	Дотоод томилолтын зардал	-	9,299,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,610,600.00	41,312,967.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	37,600,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	5,610,600.00	3,712,967.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,839,740.42	148,856,371.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,617,201.32	6,115,510.39
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,260,000.00	928,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,962,539.10	141,812,860.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,560,114.54	25,105,680.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,364,248.00	25,105,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,364,248.00	25,105,680.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	195,866.54	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	195,866.54	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	<u>219,854,246.59</u>	<u>67,022,541.52</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3,000,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	3,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(3,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	<u>219,854,246.59</u>	<u>64,022,541.52</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,526,957,048.00	2,079,519,156.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,938,248.00	32,515,382.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,938,248.00	32,515,382.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,938,248.00	-
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,938,248.00	-
120009	Бусад орлого	-	32,515,382.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,524,018,800.00	2,047,003,774.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,261,871,600.00	1,734,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,261,871,600.00	1,734,977,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	262,147,200.00	312,026,374.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	262,147,200.00	312,026,374.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,373,672,672.20	1,920,999,982.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,373,672,672.20	1,920,999,982.62
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,335,919,105.66	1,871,544,482.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	820,832,564.90	1,238,845,825.81
210101	Үндсэн цалин	547,198,819.99	764,590,735.77
210102	Нэмэгдэл	242,917,263.59	434,208,629.04
210104	Үр дүнгийн урамшуулал	30,716,481.32	40,046,461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,602,787.98	146,232,129.51
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	70,256,957.91	97,175,831.42
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	9,455,900.00	12,283,697.57
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,564,400.00	6,202,511.78
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,891,200.00	6,114,017.76
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	15,434,330.07	24,456,070.98
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	260,951,333.46	309,087,874.00
210301	Гэрэл цахилгааны зардал	12,448,067.04	17,783,973.91
210302	Түлш, халаалтын зардал	248,503,266.42	291,103,900.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	200,000.09
2105	Нормативт зардал	66,525,620.00	58,927,850.00
210502	Хоол, хүнс	66,525,620.00	58,927,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,938,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,938,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,749,648.00	14,425,533.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,938,248.00	792,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,811,400.00	13,632,633.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,257,151.32	101,086,769.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,548,301.32	87,218,169.74

**Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,708,850.00	13,868,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,753,566.54	49,455,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,557,700.00	49,455,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	37,557,700.00	49,455,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	195,866.54	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	195,866.54	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<u>153,284,375.80</u>	<u>158,519,173.38</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	37,853,942.05
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	37,853,942.05
2200	Дотоод эх үүсвэрээр	-	37,853,942.05
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	37,853,942.05
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	=	<u>(37,853,942.05)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	153,284,375.80	120,665,231.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,827,012.93	205,055,388.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,055,388.73	325,720,620.06

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад
C01	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,670,635,424.90	3,694,662,861.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,670,635,424.90	3,694,662,861.35
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	219,854,246.59	219,854,246.59
C08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,890,489,671.49	3,914,517,107.94
D01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,890,489,671.49	3,914,517,107.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	18,562,811.00	18,562,811.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,909,052,482.49	3,933,079,918.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-18,562,811.00	0.00	-18,562,811.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	64,022,541.52	64,022,541.52
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,621,724,312.59	1,973,075,024.01	3,978,539,649.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	205,055,388.73	(205,055,388.73)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,276,094,600.00	1,957,753,924.67	318,340,675.33	86.01
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,276,094,600.00	1,957,753,924.67	318,340,675.33	86.01
Бараа, үйлчилгээний зардал	2,220,910,600.00	1,908,298,424.67	312,612,175.33	85.92
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,464,953,200.00	1,238,994,325.81	225,958,874.19	84.58
Үндсэн цалин	964,056,400.00	757,443,821.25	206,612,578.75	78.57
Нэмэгдэл	475,519,600.00	441,504,043.56	34,015,556.44	92.85
Урамшуулал	25,377,200.00	40,046,461.00	(14,669,261.00)	157.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,119,400.00	146,083,629.51	37,035,770.49	79.78
Тэтгэврийн даатгал	124,521,100.00	97,033,631.42	27,487,468.58	77.93
Тэтгэмжийн даатгал	14,649,600.00	12,283,697.57	2,365,902.43	83.85
ҮОМШӨ ний даатгал	7,324,800.00	6,196,211.78	1,128,588.22	84.59
Ажилгүйдлийн даатгал	7,324,800.00	6,114,017.76	1,210,782.24	83.47
Эрүүл мэндийн даатгал	29,299,100.00	24,456,070.98	4,843,029.02	83.47
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	311,713,900.00	309,087,874.00	2,626,026.00	99.16
Гэрэл цахилгаан	20,410,000.00	17,783,973.91	2,626,026.09	87.13
Түлш, халаалт	291,103,900.00	291,103,900.00	-	100.00
Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.09	(0.09)	100.00
Нормативт зардал	96,667,300.00	58,927,850.00	37,739,450.00	60.96
Хоол, хүнс	96,667,300.00	58,927,850.00	37,739,450.00	60.96
Эд хогшил худалдан авах	3,000,000.00	2,938,500.00	61,500.00	97.95
Урсгал засвар	3,000,000.00	2,938,500.00	61,500.00	97.95
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	33,293,100.00	65,016,642.05	(31,723,542.05)	195.29
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,377,100.00	35,292,900.00	(33,915,800.00)	2,562.8
Мэдээллийн технологийн зардал	31,916,000.00	29,723,742.05	2,192,257.95	93.13
Бараа үйлчилгээний бусад зардал	128,163,700.00	87,249,603.30	40,914,096.70	68.08
Бараа үйлчилгээний бусад зардал	114,295,100.00	73,381,003.30	40,914,096.70	64.20
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,868,600.00	13,868,600.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,184,000.00	49,455,500.00	5,728,500.00	89.62
Бусад урсгал шилжүүлэг	55,184,000.00	49,455,500.00	5,728,500.00	89.62
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	55,184,000.00	49,455,500.00	5,728,500.00	89.62
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,047,003,774.00	2,047,003,774.00	-	100.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,734,977,400.00	1,734,977,400.00	-	100.00
Улсын төсвөөс санхүүжих	1,734,977,400.00	1,734,977,400.00	-	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	312,026,374.00	312,026,374.00	-	100.00
Орон нутгийн төсвөөс	312,026,374.00	312,026,374.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	205,055,388.73	(205,055,388.73)	-

**Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	325,720,620.06	(325,720,620.06)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	52.00	52.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	501.00	481.00	20.00	96.01
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	501.00	481.00	20.00	96.01
Төрийн өмчит ЕБС	501.00	481.00	20.00	96.01
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

3.1 Аудитаар нийт 73,955.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 73,955.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 163 нэр төрлийн нийт 90,056.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй байна.	1		1							1		1	
Тайлант онд 50 ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын цахим системд тайлагнахдаа 14,090.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	14,090.1	1	14,090.1			1	14,090.1					
Аудитор хөрөнгийн дансны үлдэгдэлд биет тест гүйцэтгэхэд 44 нэр төрлийн 22,011.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод хүлээн аваагүй, хөрөнгө биетээр байхгүй хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.	1	22,011.0	1	22,011.0			1	22,011.0					
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 37,853.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлаар бүртгэсэн байна.	1	37,853.9	1	37,853.9			1	37,853.9					
Дүн	4	73,955.0	4	73,955.0			3	73,955.0	1	-	1	-	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
3.2 Аудитаар нийт 53,966.1 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1,918.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 52,047.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 2 иргэн, байгууллагын 2,777.3 мянган төгрөгөөр илүү, 14 иргэн байгууллагын 5,929.0 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	-						1	-				
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 10 байгууллагын 12,885.9 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	-						1	-				
Шалгагдагч байгууллагын үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 1,918.2 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.	1	1,918.2	1	1,918.2									
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардалд 14,484.7 мянган төгрөгийн албан томилолтын зардал, 29,405.0 мянган төгрөгийн интернэт сүлжээний зардал, 3,170.0 мянган төгрөгийн сургалтын, 719.2 мянган төгрөгийн шагналын, 1,152.0 мянган төгрөгийн аудитын төлбөрийн, 3,093.0 мянган төгрөгийн эмнэлгийн үзлэгийн, 2,268.6 мянган төгрөгийн бусад жижиг зардлыг бүртгэж тайлагнасан байна.	1	52,047.9						1	52,047.9				
Шалгагдагч байгууллага нь 2021 онд батлагдсан НБББББ-ийг мөрдөж байна.	1	-						1	-				
Дүн	5	53,966.1	1	1,918.2	0	-	4	52,047.9	0	-	0	-	

Төв аймгийн Угтаалцайдам сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 11,330.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 161 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 160, хугацаа хоцорч мэдээлсэн 10, хүлээгдэж байгаа 1 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад 1 удаагийн 11,330.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.	1				1	11,330.8		
Дүн	1				1	11,330.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	-	-	0	-	0	-
Нийт дүн	1	-	0	-	1	11,330.8	0	-